

**APU COMPANY**

Absolute. Pure. Unique.



2022

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



## АГУУЛГА

### **Бидний тухай**

Эрхэм зорилго, үзэл баримтлал, үнэт зүйлс

### **Бизнесийн үйл ажиллагаа**

2022 оны Удирдлагын баг  
Үйл ажиллагааны хураангуй  
Үйлдвэрлэл үйл ажиллагаа  
Экспортын тойм  
Хүн төвтэй засаглалын бодлого  
Бидний туулсан замнал  
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
Эрүүл мэнд - Хариуцлагатай иргэн  
Эрсдэлийн удирдлага

### **Санхүүгийн үйл ажиллагаа**

Санхүү байдлын тайлан  
Орлого үр дүнгийн тайлан

### **Компанийн засаглал**

АПУ Групп компанийн бүтцэд гарсан өөрчлөлт, АПУ Групп компанийн бүтэц  
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл  
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц  
Төлөөлөн Удирдах Зөвлөл  
Ногдол ашгийн мэдээлэл  
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт  
Компанийн засаглалын үнэлгээ

### **Тогтвортой хөгжлийн тайлан**

Бизнес ба хүний эрхийн хянан магадалгаа  
Нийгэмд чиглэсэн бодлого  
Хариуцлагатай хэрэглээг дэмжих  
“Аюулгүй байдал” ба “эрүүл мэнд”  
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах  
Чанартай боловсролыг дэмжих

ЭРХЭМ ЗОРИЛГО



 АМЬДРАЛЫН МӨЧ  
БҮРИЙГ ХАМТДАА

## ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Бид бүхий л түвшинд чанарыг эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч, хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.



Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй үйл ажиллагаа явуулж, байгальд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг хамтдаа цогцлооно.



Бид баяр хөөртэй, дахин давтагдашгүй, нандин сайхан мөчүүдийг түгээнэ.





## ҮНЭТ ЗҮЙЛС



### АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалт, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг.
- “Би” бус “Бид” зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.



### БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.



### СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, ур чадварыг эрхэмлэн дээдэлдэг. Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээнд үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах зээл, шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.



### УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ

- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.



### ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахын төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддаг итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.



## 2022 ОНЫ УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын  
**ЭРДЭНЭБИЛЭГ**  
Гүйцэтгэх захирал



Батсайханы  
**ЦАЦРАЛ**  
Борлуулалт эрхэлсэн захирал



Дандарова  
**АРИУНА**  
Маркетинг эрхэлсэн захирал,  
Бүс нутгийн экспорт эрхэлсэн захирал



Жаргалсайханы  
**ИЧИНХОРЛОО**  
Захиргаа, Хүний нөөц  
эрхэлсэн захирал



Добрев  
**НИКОЛАЙ**  
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал



Гончигийн  
**ЭНХБИЛЭГ**  
Санхүү эрхэлсэн захирал



Галсумъяагийн  
**БАЯРМАГНАЙ**  
АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал,  
АПУ ХК-ийн Байгууллагын харилцаа  
эрхэлсэн захирал



Цоодолын  
**ЭРДЭНЭЖАРГАЛ**  
Бүс нутгийн экспорт эрхэлсэн  
захирал



Батхүрэлийн  
**ЧИНТОГТОХ**  
СББ ХХК-ийн Үйл Ажиллагаа  
Хариуцсан Захирал



Батсайханы  
**ГАНТИГ**  
Стратеги эрхэлсэн захирал



Пүрэвжавын  
**ЦЭНД-АЮУШ**  
Тээвэр, Түгээлт  
эрхэлсэн захирал



Эрдэнэбилэгийн  
**ОТГОНБИЛЭГ**  
Монголын зах зээл дэх  
брэнд хариуцсан Маркетингийн  
албаны дарга

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

### Борлуулалтын тоо хэмжээ сая.литр



### Цэвэр борлуулалтын орлого тэрбум төгрөг



### Үйл ажиллагааны ашиг тэрбум төгрөг



### Цэвэр ашиг тэрбум төгрөг



### Хөрөнгө оруулалт тэрбум төгрөг



### Татвар төлөлт тэрбум төгрөг



### Бүтээгдэхүүний төрөл Нэр төрлийн тоо



### Ажилтны тоо



### Онцлох төсөл

АПУ ХК нь “Шилээ дахин амьдрууля” төслийн үргэлжлэл болгон “Чи чадна” төслийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд нийт 960 гаруй агентыг төсөлд нэгтгэж, шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж чадлаа.



### Экспортын онцлох үйл явдал

Польш улсын Варшав хотын сүлжээ дэлгүүрүүдээр АПУ ХК-ийн “Чингис Хаан” брэнд амжилттай борлуулагдаж эхэллээ.



### Онцлох үйл явдал

МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тэргүүтэй албаны төлөөлөл АПУ ХК-ийн үйлдвэрүүдээр зочилж, үйлдвэрлэлийн технологи, ноу-хау, аюулгүй ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр АПУ Дэйри Монгол Сүүний үйлдвэр “Монгол Сарлаг- Гэр үйлдвэрлэл” шинэ төслөө танилцууллаа. Энэхүү төсөл нь анхан шатны үйлдвэрлэгч нэгж буюу цагаан идээний уламжлалт гэр -үйлдвэрлэлийн систем, стандартыг нэвтрүүлэн малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлж, тогтвортой амьжиргааг дэмжин, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түүхий эд нийлүүлэлтийн боломжийг нэмэгдүүлж, шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх суурь тавигдаж байна.





## ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



### АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

2022 онд бид “Аюулгүй ажиллагааны манлайлагч” аяныг зохион байгуулж “Процессын аюулгүй ажиллагаа”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”, “Аюулгүй ажиллагааны Пиллар”-ыг ажиллуулах гэсэн үндсэн 3 чиглэлд үйл ажиллагааг эхний хагас жилд зохион байгууллаа

HEINEKEN “Амь насаа хамгаалах 12 дүрэм”-ийг “Амь насаа хамгаалах 12 амлалт” болгон шинэчилж нийт ажилтнууддаа таниулах сургалт зохион байгуулав.

Аюулгүй ажиллагааг үргэлж нэгт тавьснаар эхний хагас жилийн байдлаар гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.1 байгаа нь HEINEKEN-ийн Ази тивийн бүс нутагтаа аюулгүй ажиллагааг сайн хангаж буй жишиг болж байна. орох сайн үзүүлэлт юм.

### ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНОВЧЛОЛ

Уламжлалт багцыг шинэчлэн, тэлэх зорилгоор инновац шингээсэн жор орц болон технологи, судалгаа хөгжүүлэлтийн ажил тасралтгүй хийгдэж байна. Технологийн оновчлолын хүрээнд Шар айргийн үйлдвэрлэлийн чанах болон исгэлтийн хүчин чадлыг өсгөж, Алтанговь шар айргийн экспортын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зэрэг ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ.



### ЧАНАРЫН УДИРДЛАГА

МХЕГ, АПУ ХК хамтран Хүнсний аюулгүй байдал, ОУ-ын ISO стандартуудыг хэрэгжүүлэх, баталгаажуулах тухай уулзалт, хэлэлцүүлгийг МХЕГ-ын санаачилгаар АПУ ХК-д 2022 оны 4 сарын 14-ны өдөр зохион байгууллаа. Heiquest буюу дэлхийд алдартай HEINEKEN-ийн процесс нийцлийг нийт үйлдвэрлэл, үйл ажиллагааны 12 үндсэн чиг үүргийн хүрээнд 4 охин компанийг хамруулан нэвтрүүлж ажиллаж байна.



### ПРОЦЕСС АВТОМАТЖУУЛАЛТ

Үйлдвэрлэл үйл ажиллагааны “Дижитал ба Технологи” стратеги пилларын хүрээнд ҮҮА-ны үндсэн процессыг автоматжуулах Ultimate ERP болон TPM system төслүүдийг 2022 оны эхний хагас жилд эхлүүлээ.

Бараа материалаас эхлэн, харилцагчийн гарт хүлээлгэн өгөх бүх алхмыг цахим бүртгэлд оруулан алхам тутмыг хянах боломжтой болгосон Ultimate ERP программыг бүх агуулахын үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ.



### ХУДАЛДАН АВАЛТ

Нийлүүлэлтийн гинжин хэлхээн саатал, БНХАУ-ын хөл хорио болон хилийн хязгаарлалт, Орос- Украины нөхцөл байдал болон Гадаад валют гүйлгээний хүндрэл зэрэг үүссэн нөхцөл байдалд түүхий эдийн бусад эх сурвалжуудыг бий болгох, эргэлтийн лонхны тоо хэмжээг нэмэгдүүлэх, хоёрдогч бэлтгэн нийлүүлэгчийг хөгжүүлэх, томоохон нийлүүлэгч нартай уян хатан гэрээ хэлэлцээр хийх зэргээр түүхий эд болон савлах бараа материалын тасалдалгүй байдал дээр анхаарч ажиллаж байна.



## ЭКСПОРТЫН ТОЙМ

- АПУ компани нь олон улсын зах зээлд Монгол улсаа төлөөлөн нийт 50 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг Польш, БНХАУ, ОХУ, БНСУ-ын зах зээлд экспортолж байна.
- Алтанбулаг боомт, Замын-Үүд боомтын чөлөөт бүсүүдэд Ус, Шар айргийн бүтээгдэхүүнүүдээ борлуулж эхэллээ.
- БНХАУ-ын зах зээлд АПУ ХК-ийн охин компани болох борлуулалтын “Inner Mongolia Airyou Trade LLC” компани байгууллаа.



### ПродЭкспо 2022 үзэсгэлэн

2-р сарын 7-11-ний хооронд Москва хотод зохион байгуулагдаж буй “Продэкспо 2022” үзэсгэлэнд Монгол улсаас АПУ ХК оролцлоо.

2022 оны 4-р сар



### Fuori Concorso, Итали

АПУ ХК нь Европын улс орнуудад экспортоо эрчимжүүлэх хамтын ажиллагаа, гадаад худалдаагаа өргөжүүлсээр байна.

2022 оны 5-р сар



### “Алтанговь” шар айраг

БНСУ-ын алдарт GS25 сүлжээ дэлгүүрийн нийт 7500 салбаруудаар “Golden Gobi” шар айраг албан ёсоор худалдаалагдаж эхэллээ.

2022 оны 2-р сар

### Холидей & Спа Экспо, Болгар

Болгар Улсын Аялал Жуулчлалын яамны ивээл дор зохион байгуулагдсан 38 дахь удаагийн “Holiday & Spa International Fair” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаа төлөөлж оролцлоо.



2022 оны 5-р сар

### “Чингис Хан” брэнд Польш улсын зах зээлд нэвтэрлээ.

Польш улсын Варшав хотын сүлжээ дэлгүүрүүдээр АПУ ХК-ийн “Чингис Хаан” брэнд амжилттай



2022 оны 6-р сар

## ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



### "APU LIFE" Хөтөлбөр

АПУ компани нь ажиллагсад, хамт олныхоо дунд "Эерэг амьдралын хэв маягийг түгээцгээе" уриатайгаар "APU Life" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд "АПУ ИОГ"-ийн хичээл, "АПУ МАРАФОН" гүйлтийн арга хэмжээ, "Tiger Time", "АПУ үйлдвэрлэлийн аялал", "APU Talk" зэрэг хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгуулж, ажилтан бүрийн ажил амьдралын тэнцвэрт байдал, сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарах боломж олгохоор зорин ажиллаа.



Цаашид хөтөлбөр илүү өргөн цар хүрээг хамарсан олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд хувь хүний сэтгэл зүйн эрүүл мэнд, хувь хүний арга туршлага, сонирхол хоббигоо хуваалцах боломжийг нээлттэй олгох юм.

### АПУ "Менторшип Хөтөлбөр"-2022

АПУ компанийн "Суралц, Нээ, Хөгж" үнэт зүйлийн хүрээнд хоёр дахь жилдээ зохион байгуулагдсан "Менторшип Хөтөлбөр"-ийн 2022 оны оролцогчид ажилттай төгслөө.



"Менторшип Хөтөлбөр" нь шинэ залуу ажилтнуудад карьер төлөвлөлт, хувь хүний хөгжил болоод мэргэжлийн зөвлөгөө, коучинг үйлчилгээг ажлын байрнаасаа авах боломж бүрдүүлж буйгаараа онцлог юм. 2022 оны "Менторшип хөтөлбөр"-ийн хувьд тасралтгүй суралцах соёлыг түгээх хувь хүний авьяас, ур чадварыг таньж илрүүлэх, мөн хөгжүүлэх замаар багийн болоод тухайн хувь хүний гүйцэтгэлийг нэмэгдүүлэх үндсэн гурван зорилготойгоор 2021 оны 12 сарын 8-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж, хөтөлбөрийн оролцогчид нийт 8 сарын хугацаанд PwC Академийн зүгээс зохион байгуулсан төрөл бүрийн сургалтанд хамрагдахын зэрэгцээ удирдах багийн гишүүдээс бүрдсэн Менторуудынхаа мэдлэг, туршлагаас давхар суралцаж, ийнхүү амжилттай төгслөө.

"Менторшип Хөтөлбөр"-ийн 2022 оны оролцогчид нь нийт 4 багт хуваагдаж, компанид түгээмэл тохиолдож болохуйц тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий бичил төслүүдийг нийт 3 сарын хугацаанд хэрэгжүүлж, үр дүнгээ танилцуулан шилдэг төслөө шалгарууллаа.





## ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

### “АПУ Академи”

“АПУ Академи”-ийн 2025 он хүртэлх стратеги, бодлогын баримт бичгийг боловсруулсан. Энэ хүрээнд компанийн үнэт зүйлс, үзэл баримтлалыг таниулсан сургалт болон хувь хүний хөгжилд чиглэсэн “Багаар ажиллах чадвар”, “Манлайллын чадвар”, “Асуудал шийдвэрлэх чадвар” зэрэг ерөнхий ур чадварын сургалтуудыг дотооддоо амжилттай зохион байгууллаа.



БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХУВЬ ХҮНИЙ  
ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ НИЙЦҮҮЛЖ, НЭГ СОЁЛООР ОЙЛГОЛЦОХ НЬ  
АПУ АКАДЕМИЙН АЛСЫН ХАРАА ЮМ.

APU COMPANY  
Academy. Park. Lifestyle.

APU ACADEMY  
Academy through the world.



“АПУ Академи”-ийн сургагч багш нар нь олон улсын Master trainer хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн анхны багш нар бөгөөд өөрсдийн санаачилгаар сайн дурын клуб буюу “APU Academy Community and trainers hub” үндэслэн байгуулан сургалтын хүртээмж, агуулгыг улам сайжруулахад анхааран байгууллагын тасралтгүй хөгжлийг бэхжүүлсээр байна.

### “АПУ Олимп”



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “АПУ Олимп”-2022 дотооддоо амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн тухайд АПУ Групп компанийн хэмжээнд шатар, дартс, ширээний теннис, шагайн харваа, үндэсний бөх, волейбол, сагсан бөмбөг, биллиард зэрэг спортын 8 төрлөөр 8 баг өрсөлдсөн бол багийн нийт нийлбэр дүнгээр АПУ ДЭЙРИ ХХК-ийн “Сайн” баг тэргүүлж, хамт олноо хошуучиллаа.





## БИДНИЙ ТУУЛСАН ЗАМНАЛ



### АПУ ХК-ийн Цэцэрлэгч Х. Тэрбиш:

“АПУ ХК-ийнхаа ажилтнуудад ажиллах таатай, цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг. Хүн сэтгэлээсээ, ажлыг гололгүй хийж хамт олонтой, ажилтай байх шиг сайхан зүйл байхгүй шүү дээ.

Манайх надаас гадна талбайн хоёр үйлчлэгчтэй. Тэд нар маань ажилд ороод 2, 3 жил болж байна. Анх цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах вэ зэрэг зүйлс дээр зөвлөдөг байлаа. Одоо бол бүгд ажилдаа гаршсан. Бид талбайгаа хуваарилж аваад л цэвэрлэгээгээ хийчихнэ.

Хамт олон маань намайг Тэдди ах гэдэг юм. Манайхан өглөө ажилдаа ирээд хамгийн түрүүнд мэндэлдэг хүн нь би ч байж мэднэ. Тэдди ах гээд манайхан намайг андахгүй ээ. Миний хийж байгаа ажлыг хүндэлж, миний насыг ч хүндэлдэг эерэг сайхан хамт олон дунд цаг хугацаа мөн ч хурдан өнгөрчээ. Би тэднээсээ урам, хүндлэл хүртдэг юм.”

### АПУ ХК-ийн Сэрээт ачигчийн жолооч М.Мөнх-Эрдэнэ:

“Би өглөө бүр 5:30-д сэрээд, 7:10 цаг гэхэд ажил дээрээ ирчихсэн байдаг. Уг нь ажил маань 8:30 цагт эхэлдэг ч эрт очиж өөрийгөө бэлдэх, аюулгүй ажиллагаагаа сахих, хамгийн гол нь машинтайгаа мэндлэх чухал “ажилтай”. Хүмүүс шоолох л байх, би гэхдээ машинтайгаа яг л хүн шиг ярьж, “Сайн цэнэглэгдэж, сайхан амарсан уу” гэж өглөөний ажлаа эхлүүлдэг (инээв). Яагаад гэвэл машин маань намайг ирэхэд асаж, намайг явахад сая нэг амарна. Өдрийн турш үргэлж хамт байдаг, үнэнч анд минь шүү дээ. Машин бид хоёр түүхий эд, материал хүлээн авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг түгээлтэд хүргэн ачдаг болохоор үйлдвэрлэлийн эхлэл цэгээс эцсийн цэг хүртэлх гол ажлыг нугалдаг. Ингээд бодохоор хариуцлагатай, үнэ цэнтэй сайхан ажил. Хүмүүст ажлынхаа тухай хэлэхээр бүгд л гайхаж хүлээж авна. Эхлээд сэрээт ачигч машин гэж юу болох тухай, дараа нь эмэгтэй хүн ийм ажлыг гардаж хийдэг гэж үү дээ гэсэн гайхсан асуултад нь хариулах хэрэг гардаг.”



### TIGER Шар айргийн үйлдвэрийн Инженеринг менежер, Ө.Оюунбаяр:

Ажлын ярилцлагын дараа хариу гартал 21 хоносон. Харин ажилд орох болоход “Бид чамтай эмэгтэй инженер гэж харьцахгүй. Инженер хүмүүстээ тавьдаг тэр л шаардлагыг тавьж ажиллана. Амжилт хүсье!” гэсэн товчхон яриа болж байсан юм. Үнэхээр ч өнөөдрийг хүртэл ажиллахдаа хүйсийн давуу, сул тал ажилд маань гараагүй. Үйлдвэрийн өндөр гэрлүүдийг солихоор угсармал урт шатан дээр гарах үед сандрах, өөрөө өндрөөс айдаг болохоор эвгүй санагдах үе байсан ч гэлээ “би эмэгтэй хүн” гэж бусдыг гуйхгүй, харин би инженер хүн, энэ миний хийх ёстой зүйл гэж өөрийгөө зоригжуулдаг байсан. Анх цахилгаан автоматын техникчээр ажилд орж байсан бол одоо Инженеринг менежер болж дэвшсэн байна.”

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

### УЛАМЖЛАЛ – ШИНЭЧЛЭЛ

УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ  
ХОСЛУУЛСАН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮН



### ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

ХАТУУЛАГ БАГАТАЙ  
БҮТЭЭГДЭХҮҮН





## ЭРҮҮЛ МЭНД – ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН

### СЭНГҮР ЛИГ 2022



АПУ ХК-ийн Сэнгүр брэнд нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 9 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүлэлийг ийнхүү дэмжсээр байна.

Сэнгүр брэнд нь сагсан бөмбөгийн спортыг ивээн тэтгэснээр спортын лигийн маркетинг, менежментийн үйл ажиллагааг цоо шинэ түвшинд хүргэсэн. Бидний зүгээс ҮСБХ-той хамтран NBA-н медиа сувгийн гол контентууд болох TOP 10, Highlights, Shaqtin' A fool зэргийг анхлан нэвтрүүлж, Лигийн нээлт, All Stars, Play Off, Final тоглолтуудыг мэргэжлийн өндөр түвшинд олон нийтэд хүргэж ажиллаж байна.



### ОРГИЛУУН ЛИГ 2022



Оргилуун брэндтэй ОРГИЛСОН их хүслээр нэгдсэн, сагсан бөмбөгт хайртай дуртай залуусыг АПУ ХК-ийн Оргилуун брэнд үргэлж дэмждэг. Энэ жилийн Монголын хамгийн олон сагсан бөмбөг сонирхогч залуус оролцсон Сонирхогчдын Сагсан Бөмбөгийн ОРГИЛУУН ЛИГ амжилттай зохион байгуулагдаж аваргуудаа тодруулаа. Нийт 56 багийн 1000 гаруй тамирчид, 100 гаруй дасгалжуулагчид оролцож, 5 сарын турш ширүүн өрсөлдөн АВАРГА багаар “ЗАВХАН ГАРДИ” баг шалгарч Дэд байрт “МУИС ШОНХОРУУД Hi-Pay Diamond” баг Гутгаар байрт “ЗАВХАН БРОДЕРС” баг тус тус шалгарлаа Тоглолтын шийдвэрлэх үе Аваргын төлөөх тоглолтод “ЗАВХАН ГАРДИ” 77-76 “МУИС Шонхорууд” Цувралын гурав дахь тоглолтод “ЗАВХАН ГАРДИ” баг хожсоноор лигийн аваргаар тэд тодорсон юм.





## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Геополитикийн хурцадмал байдал, урд хөршийн хил гаалийн хязгаарлалт нь дотоодын төдийгүй дэлхийн зах зээлд хүндхэн сорилтыг бий болгож, макро эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа, тээвэр ложистик, нийлүүлэлтийн гинжин хэлхээнд асуудал дагуулсаар байна. Олон улсын томоохон санхүүгийн байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн прогнозыг удаа дараа бууруулснаа зарласан нь цаашид компаниуд засаглалын түвшинд эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, аливаа тодорхойгүй нөхцөл байдлыг тооцоотой төлөвлөгөө, хурдацтай шийдвэр гаргалтаар даван туулах хэрэгцээ шаардлага тулгараад буйг илтгэж байна.






Иймд АПУ ХК нь санхүү, зардлын менежментийг сахилга баттайгаар хэрэгжүүлж, бизнесийн тасалдалгүй үйл ажиллагааг ханган ажиллахын тулд эрсдэлийн удирдлагын оновчтой бодлогыг бүхий л алба нэгжүүдийн түвшинд хэрэгжүүлж, экспортын зах зээлээ тэлэх чиглэлд

төвлөрөн ажиллаж байна. Мөн түүнчлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд олон төсөл хөтөлбөрүүдийг (Жишээлбэл: “Тогтвортой хөгжлийн бодлого”) дэмжин оролцохын зэрэгцээ, шингэн хүнсний зохистой хэрэглээг таниулах, үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Шилээ дахин амьдруулъя”, “Соёлоор гоёно”, “Маргаашийн манлайлагчид” зэрэг томоохон компани ажлуудыг зохион байгуулсан билээ.

2022 он гарснаар АПУ групп компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын программын тусламжтайгаар эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийж, бууруулах төлөвлөгөөг боловсруулан, мөшгөлт хийж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллахын зэрэгцээ, эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор тодорхой төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд дэмжин ажилласан.

## ТОМООХОН ЭРСДЭЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ



<p>ТОП ЭРСДЭЛҮҮД</p>	<p>ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?</p>	
<p>1</p> <p>ГЕОПОЛИТИКИЙН ЭРСДЭЛ</p>	<p>Орос-Украины хурцадмал байдлаас шалтгаалан олон улсын зах зээлд тодорхойгүй байдал үүсч стратегийн ач холбогдол бүхий бараа таваар нэн ялангуяа цахилгаан эрчим хүч, нефть, улаанбуудай (нийт гадаад худалдааны 25%), бордоо, арвай (нийт гадаад худалдааны 30%), наранцэцгийн тос (нийт худалдааны 60%), эрдэнэ шиш (14%) шаардлагатай бусад ашигт малтмалын хомстол үүсэхийн зэрэгцээ үүнтэй холбоотой үйлдвэрлэл, гадаад худалдаа, тээвэр ложистикийн асуудлууд нийлүүлэлтийн болон инфляцын дарамтыг дагуулж эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд томоохон эрсдэлийг учруулаад байна. Уг нөхцөл байдал нь АПУ ХК-ийг шаардлагагүй зардлаа танах, үйлдвэрлэлийн төлөвлөлтийг сайтар тооцоолж хийх (Компани дотооддоо мэдээллээ хурдан шуурхай солилцох байдлыг сайжруулах), back up нийлүүлэгчдийг эрэлхийлэх, төлбөр тооцоо шилжүүлгийг үүсмэл санхүүгийн хэрэгслийг ашиглах замаар эрсдэлийг бууруулахыг шаардаж байна.</p>	
<p>2</p> <p>МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ</p>	<p>Орос-Украины дайн, КОВИД-19-н тархалт үргэлжилсээр байгаа нөхцөл байдалтай холбоотой:</p> <ul style="list-style-type: none"> <li>Хятадын хил хаагдах, улмаар гол түүхий эдийн экспортын зорилтдоо хүрч чадахгүй болох, гадаад валютын нөөц буурах, төсвийн алдагдал нэмэгдэж гадаад өрийн дарамт өсөх</li> <li>Стагфляци- Нийлүүлэлтийн гинжин хэлхээний саатал, гол ТЭМ болох хүнс, ургац тариалалтын бордоо, газрын тос, байгалийн хий гэх мэт стратегийн ач холбогдол бүхий голлох бараа таваарын эрэлт өссөнтэй холбоотойгоор олон улсад инфляц өндөр түвшинд хадгалагдсаар бодлогын хүүг өсгөж хүүний түвшин нэмэгдэх, валютын ханш савлаж сулрах, ажилгүйдэл нэмэгдэх, ДНБ агших зэрэг стагфляци бүхий эдийн засгийн хямрал тодорхой хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна. Үүний дагуу Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг томоохон ОУ-н байгууллагууд эдийн засгийн өсөлтийн прогнозын бууруулснаа зарласан.</li> <li>Эдийн засаг хямарснаар ард иргэдийн бодит орлого буурах, худалдан авах чадвар сулрах, үйлдвэрлэлийн өртөг нэмэгдэх, бизнесийн үйл ажиллагаа хумигдах, ажилгүйдлийн түвшин нэмэгдэх зэрэг сөрөг үр нөлөөг дагуулж байна.</li> </ul>	
<p>3</p> <p>COVID-19 ЦАР ТАХАЛ</p>	<p>Ковид-19 компанийн үйл ажиллагаанд учруулж буй нөлөөлөл:</p> <p><b>Бизнес орчин:</b> БНХАУ хил гаалийн хатуу бодлого баримталж байгаагаас шалтгаалан компанид үзүүлэх эдийн засгийн дарамт нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь гол түүхий эдийн тээвэрлэлтийн зардал өсөх, үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ буурах зэргээр илэрч байна. Нийгэм эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэн инфляц, валютын ханш өсөх, өрхийн бодит орлого буурах зэрэг борлуулалтад нөлөөлөхүйц эрсдэл хэвээр байна.</p> <p><b>Хүний нөөц:</b> Коронавирусын вариантууд хурдтай өөрчлөгдөж, хоруу чанар буураагүй байгаа үед ажилтнуудын хариуцлагагүй байдлаас шалтгаалсан ажлын байрны халдвар өсөх магадлалтай. Улс орнууд хил гаалийн хязгаарлалтыг бууруулсантай холбогдуулан гадагшаа чиглэсэн хөдөлгөөн огцом өссөн нь цаг хугацаандаа шаардлагатай ажлын байрны нөхөлт хийх боломжийг бууруулж байна.</p>	
<p>4</p> <p>ХЭРЭГЛЭГЧИЙН БОДИТ ОРЛОГО БУУРАХ, ХЭРЭГЛЭЭНИЙ ШИЛЖИЛТ</p>	<p>Монгол улсын хэмжээнд медиан цалингийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн хэдий ч инфляцын өсөлт бодит орлогын хэмжээг бууруулахад хүргэлээ. Мөн гадаад макро орчны нөлөөлөөс хүн амын эдийн засгийн идэвх суларч ажилгүйдлийн түвшин нэмэгдэн орлогогүй иргэдийн тоо өссөнөөр хүмүүсийн худалдан авах чадварт нөлөөлж хэрэглээний шилжилтийг үүсгэж байна.</p>	
<p>5</p> <p>КИБЕР ХАЛДЛАГА, ИТ ДОГОЛДОЛ</p>	<p>Амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр мэдээллийн систем, техник технологийн өөрчлөлтүүд бизнесийн үйл ажиллагаанд томоохон байр суурийг эзэлсээр байна. Үүний зэрэгцээ байгууллагын систем, өгөгдөл, сүлжээг устгах, хакердах зорилготой халдлагын тоо дэлхийн хэмжээнд өсч мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэл өсөн нэмэгдэх болсон. Энэ чиглэлд АПУ ХК үндсэн сервер, системийн доголдолгүй байдлыг хангах талаас томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлсээр байна.</p> <p>Хууль эрх зүйн орчин, Алсын хараа “2050”, Засгийн газрын 2021-2024 үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу “Цахим Үндэстэн” уриалга, бодлого (Төсвийн 2%): Дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавч, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан зорилгыг тавин ажиллаж байгаа нь хэрэгжүүлэх түвшиндээ бизнест том боломжийг бий болгож байгаа.</p>	



Эрсдэлийн түвшин өссөн



Эрсдэлийн түвшин буурсан



Хэвээрээ

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын бүтцэд орсон өөрчлөлтүүд:

Геополитик болоод Хятад улсын хил, гаалийн хязгаарлалттай холбоотой түүхий эд материалын татан авалтуудын нийлүүлэлт хойшлогдсноор урьдчилж төлсөн зардлын хэмжээ нэмэгдсэн. Мөн харилцагчидаа дэмжих болон экспортын үйл ажиллагааг тэлэх үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор борлуулалтын авлага нэмэгдсэн байна.

Гадаад валютын хомсдлоос хамааран түүхий эд материалын төлбөр тооцоог хойшлуулснаар өглөгийн хэмжээ өссөн. Үүнээс гадна групп компанийн хэмжээнд хэрэгжиж буй төслүүд тэр дундаа Дижитал концепт ХХК-ийн хөрөнгө оруулалтаас хамааран холбогдох өр төлбөр, зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

		2021Q4	2022Q2 Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	251,636.75	320,268.58
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	365,575.44	409,094.78
<b>Нийт хөрөнгө</b>	сая.төг	<b>617,212.20</b>	<b>729,363.36</b>
Өр төлбөр	сая.төг	112,225.69	206,013.73
Эздийн өмч	сая.төг	504,986.51	523,349.63
<b>Нийт өр төлбөр ба Эздийн өмч</b>	сая.төг	<b>617,212.20</b>	<b>729,363.36</b>

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2022 оны 2-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад АПУ Групп компанийн цэвэр борлуулалтын орлого 28%-иар өндөр, цэвэр ашгийн хэмжээ 1%-иар тус тус өссөн.

Борлуулалтын орлогын өсөлт нь сүү сүүн бүтээгдэхүүн болон Дижитал концепт ХХК-ийн өсөлтөөс хамаарсан. Энэ онд олон улсад болж буй үйл явдлууд бидний хувьд томоохон сорилт, хүндрэлүүдийг бий болгож байгаа ч олон улсын зах зээлийг тэлэх зорилготой үйл ажиллагаануудыг тасралтгүй хэрэгжүүлж Солонгос улс руу Алтанговь шар айргаар нэвтэрсэн амжилттай байна.

Нөгөө талаас олон улс дахь нөхцөл байдлаас хамаарсан хүндрэлийг даван туулахын тулд АПУ групп компанийн хэмжээнд “Хямралын үеийн төлөвлөгөө”-г боловсруулан үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр ашигт эерэг нөлөөг үзүүлж, өнгөрсөн жилийн ашгийг хадгалсан үзүүлэлттэй байна.

Covid-19-ийн хямралын дараах ажилчид руу чиглэсэн хүн төвтэй хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, эрүүл чанартай олон улсын стандартад нийцсэн брэнд бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хийгдэж буй хүн нийгэмд хандсан хөтөлбөрүүдийг идэвхтэй хэрэгжүүлж буй нь удирдлага маркетингийн зардлуудыг өсөхөд гол нөлөө үзүүлжээ.

		2021Q2 Аудитлагдаагүй	2022Q2 Аудитлагдаагүй
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	305,019.0	391,076.1
Борлуулалтын өртөг	сая.төг	152,686.0	201,479.7
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	сая.төг	<b>152,333.0</b>	<b>189,596.4</b>
Үйл ажиллагааны зардал	сая.төг	53,332.0	82,995.9
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	сая.төг	<b>99,001.0</b>	<b>106,600.5</b>
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	1,065.0	(1,416.8)
<b>Татварын өмнөх ашиг</b>	сая.төг	<b>100,066.0</b>	<b>105,183.8</b>
Орлогын албан татварын зардал	сая.төг	18,767.0	23,052.4
<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	сая.төг	<b>81,299.0</b>	<b>82,131.4</b>
Үйл ажиллагааны маржин		32%	27%
Цэвэр ашгийн маржирн		27%	21%



## АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЦЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:

АПУ ХК-ийн экспортын үйл ажиллагааг тэлэх зорилгоор 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болох Inner Mongolia Aipiyou Trade LLC нь БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын

06-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба групп компаниудын бүтэц доорх байдалтай байна.

### АПУ Групп компанийн бүтэц

## APU COMPANY

Absolute. Pure. Unique.



APU DAIRY

Absolute. Pure. Unique.



APU TRADING

Absolute. Pure. Unique.



CHINGGIS KHAN  
INTERNATIONAL LIMITED



爱啤酒  
Inner Mongolia APU trading company

Хараат компани

DIGITAL  
CONCEPT

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

### Хувьцаа эзэмшигчдийн хурал

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концерт холл танхимд болж, дараах шийдвэрүүдийг гаргав.

Үүнд:

1. АПУ ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2021 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов.

Үүнд:

#### Ердийн гишүүн


1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. Сергей Громов
4. Д.Миеэгомбо
5. Кеннет Чу
6. Сэн И-Ин

#### Хараат бус гишүүн

1. Ё.Гэрэлчулуун
2. О.Одбаяр
3. Ж.Үнэнбат

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид  
(2022 оны 04 сарын 08-ны өдрийн байдлаар)



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон. Үүнд:

1. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Томас Холландын оронд Доржийн Миеэгомбо сонгогдов.
2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Өлзийдэлгэрийн Батбаярын оронд түр томилогдсон Одончимэдийн Одбаярыг нөхөн сонгов.



**ПҮРЭВИЙН  
БАТСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
бөгөөд ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч  
Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга,  
гишүүн, АПУ ХК-ийн 0.08%-ийн  
хувьцаа эзэмшигч



**БҮРЭНТОГТОХЫН  
БАТБАЯР**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү  
эрхэлсэн захирал  
АПУ ХК-ийн 0.05%-ийн хувьцаа  
эзэмшигч



**СЕРГЕЙ ГРОМОВ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**КЕННЕТ ЧУ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азиа Пасифик  
компанийн Ази-Номхон далайн  
бүсийг хариуцсан Гүйцэтгэх  
захирал  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**СЭН И-ИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азиа Пасифик компанийн  
Ази-Номхон далайн бүсийн Хууль  
эрхзүй хариуцсан захирал  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ДОРЖИЙН  
МИЕЭГОМБО**

ТУЗ-ийн ердийн гишүүн

"ЁС" ХХН-д зөвлөх  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**Одончимэдийн  
ОДБАЯР**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ард даатгал ХК, Ард холдинг ХХК,  
Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн  
гишүүн  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЁНДОН-ОЙДОВЫН  
ГЭРЭЛЧУЛУУН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЖИГЖИДИЙН  
ҮНЭНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЧАДРААБАЛЫН  
АРИУНСАН**

ТУЗ-ийн нарийн бичгийн  
дарга

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй




## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 17-ны өдрийн шийдвэрээр 2021 оны хоёрдугаар хагаст ногдох ногдол ашгийг нэгж хувьцаанд ₮60 (жаран төгрөг)-өөр тооцож хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит

хурлын бүртгэлийн өдөр буюу 2022 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр тогтов. Ийнхүү 2021 онд эхний хагаст ₮46, хоёрдугаар хагаст ₮60 буюу нийт 106 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар болов.

### Ногдол ашгийн хуваарилалт (2018 оноос хойш)



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсаны дагуу АПУ ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.18-ны өдрийн №22/10 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодексст нийцүүлэх ажлыг хийхээр төлөвлөсөн бөгөөд доорх дүрэм журмуудыг шинэчлэх болон шинээр батлахаар тусгав.

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам – шинэчлэх
2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм – шинэчлэх
3. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дүрэм – шинэчлэх
4. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дүрэм–шинэчлэх
5. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын тухай дотоод журам–шинэчлэх
6. Эрсдэлийн удирдлагын бодлого–шинэчлэх
7. Дотоод хяналтын бодлого–шинэчлэх
8. Дотоод аудитын бодлого–шинэчлэх
9. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам–шинэчлэх
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам–шинэчлэх
11. Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай дотоод журам–шинэчлэх
12. Ногдол ашгийн журам–шинэчлэх
13. Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны журам–шинэчлэх
14. Цалин урамшууллын бодлого– шинэчлэх
15. Залгамж халааны бодлого– шинэчлэх
16. Ёс зүйн дүрэм–шинэчлэх
17. Шүгэл үлээх дүрэм журам– шинэчлэх
18. Комплайнсын загвар– шинээр батлах
19. Тогтвортой байдлын бодлого– шинээр батлах
20. Оролцогч талуудтай харилцах бодлого– шинээр батлах

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

### Нэгдсэн үнэлгээ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн	
			онгоо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%
5	Эрсдэлийн удирдлага	8	6	75%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3	50%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%
8	Компанийн соёл	6	3	50%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>72</b>	<b>54</b>	<b>75%</b>

- авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

## БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН ХЯНАН МАГАДЛАГАА

## Бидний зорилт:

Хүний эрхийг дээдэлж, Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх.

АПУ компанид хүний эрхийн сөрөг нөлөөллийн эрсдэл бий эсэх, хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тайлагнах зорилгоор “Хүний эрхийн хянан магадлагаа”-г MDS Khanlex хуулийн фирм, IWFCI Mongolia ТББ зэрэг байгууллагуудтай хамтран хийлээ.

Уг судалгааг хийхдээ компанийн дотоод батлагдсан дүрэм журам нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц: “Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” зэрэг нийцлийг хянаж, мөрдсөний дагуу явууллаа. Мөн цаашлаад компанийн дотоодын ажилтнуудаас бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетинг, зар сурталчилгаа, хөдөлмөрийн харилцаа, гэсэн хэсэгт хуваан судалгааг авсан бөгөөд үүн дээр үндэслэн зөрчил илрүүлэх, сайжруулах процесс санал зөвлөмжийн тодорхойлоо.

## Хөхүүл ээжийн булан

Хөхүүл эхчүүдэд зориулсан жишиг буланг “Mommy’s corner” нэртэйгээр АПУ Дэйри ХХК-ийн оффист байршууллаа. “Mommy’s corner”-ийг байгуулан компанид ажиллаж буй хөхүүл эхчүүдийн хэрэгцээг хангаснаар бүтээмжийг дээшлүүлж, улмаар соёл, ажлын байрны таатай орчныг бий болгож байна. Эхийн сүүгээр хооллох,

ажлын байранд хөхөө саах орчныг бүрдүүлэх нь хүн амын эрүүл мэнд, ирээдүй хойч болсон үр хүүхдийн эрүүл өсөлтөд зөргөөр нөлөөлсөн ажил болно гэж итгэж байна. Амьдралын мөч бүрийг хамтдаа. Жич: Уг загвар төслийг UNICEF-ээс гаргасан эхчүүдэд зориулсан булан тохижуулах зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэв



## ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



АПУ ХК Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт зориулан “Тогтвортой маргаашийн төлөөх тэгш, хүртээмжтэй өнөөдрийг бүтээх нь” сэдвийн хүрээнд цаашдын бодлого, зорилтын талаар хэлэлцлээ.



Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт зориулан АПУ ХК-ийн хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд цаашид баримтлах бодлого, зорилтуудаа эмэгтэй ажилтнууддаа танилцууллаа.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагаас 2022 оны уриалга болгон гаргаж буй “Тогтвортой маргаашийн төлөөх” санаачилгад нэгдэн албан ёсны зөвшөөрөлтэйгөөр энэхүү арга хэмжээг зохион байгуулж хэрхэн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, компанийн нийгэм, олон нийт төдийгүй хүний нөөцийн бодлогын зорилтуудаа хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх талаар хэлэлцлээ. Энэ үеэр АПУ ХК-ийн Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал Ж.Ичинхорлоо цаашид компанидаа хэрэгжүүлэхээр зорьж буй нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн эрүүл мэнд, бие бялдрын эрүүл мэнд тэргүүтэй хүн төвтэй менежментийн бодлогын чиглэлийг танилцуулсан ба компанийн хэмжээнд эмэгтэйчүүдийн манлайллаар хүрэх олон эерэг өөрчлөлт, хөгжлийн боломж байгааг чухалчиллаа.

Мөн арга хэмжээний үеэр эмэгтэйчүүдийн дуу хоолойг илэрхийлэх гүүр болсон клуб болох “The Circle” Sustainability Club нээлтээ хийсэн нь онцлог байв.



## НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОДЛОГО



### Нийгэмд чиглэсэн ээлтэй бодлого

#### Бидний зорилт:


Хэрэглэгч, харилцагч, олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлэв

#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



### “Хамтдаа” Харилцагчийн нэгдсэн чуулган

Үйлдвэрлэл, Худалдаа, Үйлчилгээний салбарын хамтрагч, харилцагч байгууллагуудтай хамтран зах зээлийн хүндрэлтэй нөхцөл байдалд хэрхэн хамтарч ажиллахаар хэлэлцэж, нээлттэй санал солилцох зорилгоор АПУ ХК нь уламжлал болсон харилцагчийн нэгдсэн чуулганаа “Сорилт, Гарц, Оролцоо” сэдвийн дор зохион байгууллаа. Чуулганаар бизнесийн орчны хүндрэлтэй нөхцөл байдал, хил гааль, тээвэрлэлт, олон улсын геополитикийн асуудлуудаас үүдэлтэй түүхий эд, бараа материалын тасалдал, валютын ханшийн өсөлт тэргүүтэй хүчин зүйлсийн улмаас бараа, бүтээгдэхүүний үнэ огцом өсөхөд хүрээд байгааг бизнес эрхлэгчид онцолсон бол ҮСХ-ны төлөөллүүдийн зүгээс эдийн засгийн өөрчлөлт, түүхий эдийн тасалдал, инфляц, үнийн суурь хүчин зүйлсийн талаар бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргэж, цаашид авах арга хэмжээ, шийдэл гарцыг хамтдаа хэлэлцлээ.



### “Чи Чадна- Шилээ дахин амьдруулъя” – төсөл

АПУ ХК нь “Шилээ дахин амьдруулъя” төслийн үргэлжлэл болгон шилний хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах хэрэглээний хэв маягийг бүрдүүлэх зорилгоор “Чи чадна” төслийг амжилттай хэрэгжүүлээ. Төслийн хүрээнд хэрэглэгч, түгээгч, тээвэрлэлтийн байгууллага болох бүхий л оролцогч талуудыг хамруулан шилийг онцгой үнээр эргүүлэн авч харилцан эдийн засгийн өгөөжийг хүртэх зарчмаар нийт 960 гаруй агентыг төсөлд нэгтгэж, шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж чадлаа. Шилээ дахин амьдруулснаар түүхий эд, орц найрлагад орох байгалийн нөөц баялгийг хэмнэх, шилний импортын хамаарлыг багасгаж, хил гаалийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, шил шинээр үйлдвэрлэхээс гарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг нийгэм эдийн засаг, байгаль орчинд ихээхэн өндөр ач холбогдолтой юм. Бид шингэн хүнсний салбарт тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаа байгальд орчинд ээлтэй, хариуцлагатай байх чиглэлд хамтын бодлого баримтлан ийнхүү ажиллаж байна.



## НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОДЛОГО



### Сүүний ашиг шим

#### Бидний зорилт:

Сүү сүүн бүтээгдэхүүний ашиг шимийг сурталчлан таниулах, хүүхэд бүрийн сүүний хэрэглээг нэмэгдүүлэх.

Хүүхэд бүр эрүүл саруул өсөн торниход сүү сүүн бүтээгдэхүүний оруулах үр нөлөө өндөр гэдгийг мэргэжилтнүүд онцолдог. Иймд сүүний хэрэглээ, ач холбогдлыг эцэг эх, хүүхэд багачуудад таниулах зорилгоор “Дэлхийн Сүүний Өдөр”, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан АПУ Дэйри ХХК-ийн зүгээс “GOOD VIBE” брэндийн асрыг Улаанбаатар хотын 3 цэгт байршуулан сүүний ашиг шимийг олон нийтэд сурталчиллаа. Бид Монголчуудынхаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах,



импортыг орлохуйц, хүнс урлахуйн уламжлалт ур, ухааныг шинэчлэл, дэвшилтэй хослуулан хөгжүүлсэн “Сайн”, “Дээж”, “Good Vibe”, “Цэвэр сүү” буюу үндсэн 4 брэндийн 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэн ажиллаж байна.



#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:





## ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



### Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх “Соёлоор Гоёно” төсөл

#### Бидний зорилт:

Язгуур соёл, үндэсний үнэт зүйлсээ дээдлэн эрхэмлэж, үр хойчдоо өвлүүлэн үлдээх өв соёлыг дэмжих.

#### Соёлоор Гоёно

АПУ ХК нь нийгмийн эерэг өөрчлөлт бий болгох зорилготойгоор “Соёлоор Гоёно” төслийг 2021 оноос эхлүүлэн үндсэн гурван чиглэлийн хүрээнд нөлөөллийн компани ажилуудыг үе шаттайгаар амжилтай зохион байгуулсаар байна. Үүний үр дүнд байгаль эх дэлхийдээ ээлтэй амьдрах соёл, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлж, язгуур өв соёлоо сурталчлан “Дэлхийд Монгол Соёлоор Гоёно” хэмээх уриан дор дэлхийн 15 улс, эх орныхоо 30 гаруй цэгээс хамтдаа бий биелгээгээ биелэн үндэсний соёлоороо гоёлоо. “Соёлоор Гоёно” төслийн хүрээнд



бид өнгөрсөн хугацаанд нийт 55 гаруй төрлийн контентыг олон нийтэд түгээж, бидний өөрсдийн бүтээхийг хүсдэг соёлыг түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан хамтын дуу хоолой, хүсэл тэмүүлээ уг төслөөр дамжуулан илэрхийлсээр байна. Энэхүү нийгэмд чиглэсэн “Соёлоор Гоёно” төсөл нь 13 дахь удаагийн соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын “Мөнгөн Мод 2021” наадамд “Шилдэг зар сурталчилгаа” төрөлд шалгарсан анхны бүтээл боллоо.



#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:





## “АЮУЛГҮЙ БАЙДАЛ” БА “ЭРҮҮЛ МЭНД”



### “Аюулгүй байдал”

#### Бидний зорилт:

Амь насаа хамгаалах амлалтуудыг бүрэн дагаж мөрдөх

#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



HEINEKEN-ийн амь насаа хамгаалах амлалтууд нь манай компанид ажилладаг бүх хүмүүст хамаатай аюулгүй ажиллагааны дүрмүүд юм. Эдгээр нь эрсдэлийг бууруулах хөтөлбөрөөр дэмжигддэг бөгөөд ноцтой, хүний амь нас алдах ослоос урьдчилан сэргийлэх түлхүүр юм.

Үйл ажиллагаа эрхэлдэг бүх компаниуд Амь насаа хамгаалах дүрмийг дагаж мөрдөх ёстой. 2022 онд бид үйлдвэрлэл үйл ажиллагаандаа амь насаа хамгаалах 12 амлалтыг бүрэн мөрдөн ажиллаж байна.

**АМЬ НАСАА ХАМГААЛАХ 12 АМЛАЛТ**

- Согтуурх, мансуурахаас зайлсхий
- Хурдээ хоёр гараар барь, жолоодлогод төвлөр
- Суудлын бүсээ зүү, хамгаалалтын малгай өмс
- Зөвшөөргдсөн хурдаар яв
- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй ашигла
- Засаар, үйлчилгээ хийхдээ Цоож-Пайз ашигла
- Нүүрсүлчийн хийтэй орчинд шаардлагатай арга хэмжээг хангаж ажилла
- Аюултай бодистой харьцах үедээ аюулгүй байдалаа ханга
- Хязгаарлагдмал орчинд орохдоо зөвшөөрөл ав
- Өндөрт ажиллахдаа унахаас сэргийл.
- Халуун ажлыг зөвшөөрөл авч хий
- Сэрээт ачигч машины аюулгүй байдлыг хангаж ажилла

#### Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэлээ.

2022 оны тухайд бид АПУ компанийн хэмжээнд гэрээт мэргэжлийн байгууллагаар бүрэн хэмжээний “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэж гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Мөн эрсдэлийг даатгагч “Хаан даатгал” компанитай хамтын ажиллагааны хүрээнд Англи улсын “Tyser risk management” компанийн гадаад мэргэжилтнүүдээр үйлдвэрлэл, инженерингийн тоног төхөөрөмж, байгууламжуудад эрсдэлийн үнэлгээ хийлгэж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байна.

#### Аюулгүй байдлын стратеги

АПУ ХК нь аюулгүй байдлын шинэ стратегийг 2021 оноос эхлэн компанийн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж ирсэн. Үүний дагуу учирч болох хамгийн өндөр эрсдэлүүдийг тодорхойлж, хамт олноороо аюулгүй байдлаа хангахад идэвх оролцоотой хандсанаар замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлого, гэрээлэгчийн аюулгүй байдал, аюулгүй байдлын манлайлал гэсэн гурван чиглэлд анхааран ажиллаж, түүнд зориулсан олон хөтөлбөрийг компанийн хэмжээнд амжилттай хэрэгжүүллээ. Мөн нийт 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, ажлын байран дээрх Эргономикийн зөвлөгөөний гарын авлагыг боловсруулж, Аюулгүй байдлын манлайлагч тэмцээнийг зохион байгуулж, нийт ажилчдад аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх давуу тал, осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх чадавхыг таниуллаа.

#### Замын хөдөлгөөний аюулгүй байдал

Компанийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нийт 14 удаагийн ХАБЭА үзлэг, шалгалт аудит хийж, 156 зөрчил илэрснээс 78%-ийг нь засаж залруулсан байна. Мөн МХГ, ОБЕГ-ын 5 удаагийн шалгалтанд амжилттай хамрагдаж, 3440м2 талбайн тэмдэг, 52 ширхэг самбар 1200м урт тууз зэргийг байршуулан жолоодлогын үед гарч болохуйц ослоос сэргийлж ажиллаж байна. Мөн том оврын 78 тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөнийг хянах хар хайрцаг, /Wi-Fi/ ухрах камер байршуулах туршилт хийлээ.



#### Сайн туршлага

АПУ компанийн үйлдвэрлэл үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нийт ажилтнуудын ихэнх нь замын хөдөлгөөнд тээврийн хэрэгсэл жолоодон байнга оролцдог. Иймд замын хөдөлгөөнд соёлтой оролцох, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор сар бүр хамт олондоо “Аюулгүй ажиллагааны манлайлагч” болсон жолооч нар өөрсдийн туршлага, ур чадвараа хуваалцсан блогийг тогтмол хүргэлээ.



## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БУУРУУЛАХ



### Хог хаягдлын менежмент

#### Бидний зорилт:

АПУ ХК нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилготой

#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



#### Хог хаягдал

АПУ ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах хүрээнд Шинэ Шил ХХК, Пластик сентер ХХК, Ногоон Ойм урлан ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаа. Энэ хүрээнд үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг энэ үеийн өмнөх үетэй харьцуулахад 30% -аар бууруулж, хаягдал шилийг хөөсөн шил боловсруулах үйлдвэр Шинэ Шил ХХК-д, хаягдал гялгар уутыг Пластик сентер ХХК-д тус тус нийлүүлэн



нүхэн жорлонгийн доторлогоо, барилгын дулаалгын хөөс хийхэд зориулаа. Мөн үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг малчид фермерүүдэд, хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэрт тогтмол нийлүүлж байна.

#### Хаягдал шил

Бид хаягдал шилээ дахин ашиглах зорилгоор Шинэ Шил ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу одоогийн байдлаар 200 тонн хаягдлын шилийг нийлүүлсэн байна. Хөөсөн шил үйлдвэрлэх туршилтыг анхлан явуулахад АПУ компаниас гарч байгаа хаягдал шилний цахиурлаг түүхий эдийн шаардлагыг бүрэн хангаж байсан тул ийнхүү эдийн засгийн эргэлтэнд оруулж эхэллээ. Хөөсөн шил нь импортыг орлох бүтээгдэхүүн бөгөөд галд тэсвэртэй, цантахгүй, бат бөх, амархан зүсэгддэг зэрэг олон давуу талтай юм.



#### Шингэн хаягдал



Шингэн хаягдлын хувьд үйлдвэрээс органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизельгур зэрэг гардаг ба дахин ашиглалтыг онцгой анхаарч ажиллаж байна. Тухайлбал өмнө нь бид шар айргийн шүүлтийн процесст оролцдог Кизельгургыг хаягдал усны шугамд хаядаг байсан бол одоо шүүх хатаах төхөөрөмж суурилуулан хатуу хог хаягдал болгон ашиглаж байна. Кизельгур нь байгалийн нэгдэл бөгөөд агрохими хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг учир газар тариалангийн салбар болон зам барилга салбарт ашиглах боломжтой гэдэг эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн судалгааны ажлыг “Ойм Ногоон урлан ХХК”-тай хамтран эхлүүлсэн. Үйлдвэрлэлээс гарч буй нийт хог хаягдлыг 9.8 хувийг эзэлдэг кизельгурийн эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг бид ийнхүү судалж байна. Үүний хамгийн том ач холбогдол нь хөрсний доройтол, цөлжилтийг бууруулахаас гадна төвлөрсөн хогийн цэгт очих хаягдлыг бууруулах үр нөлөөтэй юм.



## ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



### Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих "Маргаашийн Манлайлагчид" төсөл

#### Бидний зорилт:

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусын боловсролд хөрөнгө оруулж, сурч, хөгжих, нийгэмдээ ээлтэй үйлс хийх боломжоор хангах

Нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах манлайлагчдыг нээн илрүүлэх, тэдний сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг АПУ ХК нь 2021 оноос эхлүүлэн хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд "Хүний хөгжлийн тогтвортой бодлого" -д онцгойлон анхаарч хөтөлбөрт оролцогч оюутан залуусыг нийгэмдээ эерэг хандлага түгээж бусдыг хүндлэх, ойлгох соёлыг дэлгэрүүлэх зорилготой сургалтуудад шат дараатай хамрууллаа.

Тухайлбал НҮБ-ын Залуучуудын Зөвлөх Хорооны "Global Goals for Youth" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "ЗҮРХЭЛ" төсөлтэй хамтарч Дохионы хэлний хурууны үсэг, энгийн өдөр тутмын хэллэгүүдийг заах сургалтыг амжилтай зохион байгуулснаар бид сайн сайхан, хүн бүрт хүртээмжтэй нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулж, нийгэмд чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Мөн төслийн хүрээнд Хип Хоп бүжгийн урлагт дурлагч энэ төрлөөр сонирхон хичээллэгч хүүхэд залуусыг дэмжиж, олон нийтэд Хип Хоп бүжгийг сурталчлан таниулах зорилготойгоор "Монголын Гудамжны Хип Хоп бүжгийн холбоо"-той хамтран "Level Up .vol.4 Hip hop battle"-ийг зохион амжилттай байгууллаа.

#### ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Тэгш, хүртээмжтэй боловсролыг дэмжих







# APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,

Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063

[www.apu.mn](http://www.apu.mn)